



МОНГОЛ УЛС  
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2021 оны 05 сарын 11 өдөр

Дугаар А/233

Чингис хот

Иргэний газар өмчлөх эрхийг дуусгавар  
болгож, газар эзэмшүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, 29.3, 30 дугаар зүйлийн 30.1.5, Газрын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.3.2, Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Иргэн Сампил овогтой Ганбаатар (СЮ62101675)-ын гаргасан хүсэлтийн дагуу Хэрлэн сумын 4 дүгээр баг Пунцаг гудамж Б-43 тоот байршилтай 2311036727 нэгж талбарын дугаар бүхий гэр бүлийн хэрэгцээний зориулалттай 4114м<sup>2</sup> газрын өмчлөх эрхийг 2021 оны 05 дугаар сарын 12-ны өдрөөс дуусгавар болгож, иргэн С.Ганбаатар (СЮ62101675)-т үйлчилгээний зориулалтаар 40 жилийн хугацаатай эзэмшүүлсүгэй.

2. Иргэн С.Ганбаатарт эзэмшүүлсэн газрын кадастрын зураглалыг хавсралтаар баталсугай.

3. Газар эзэмших эрхийн гэрчилгээг олгож, гэрээ байгуулан хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Д.Баярхүү)-т үүрэг болгосугай.

4. Эзэмшүүлсэн газрыг зориулалтын дагуу эзэмшиж, гэрээний хэрэгжилтийг биелүүлж, жил бүр дүгнүүлж байхыг иргэн С.Ганбаатарт даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ИДЭРБАТ

231011492